



Үндэсний виз мэдүүлэх заавар

Герман улсад дахин нэвтрэх виз

Үндсэн заавар

- Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэхийн тулд Герман дахь Гадаадын Харьяат Иргэдийн газраас зөвшөөрөл авдаг. Тус газраас зөвшөөрөл ирсний дараа виз олгох боломжтой.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацаа нь 4 долоо хоног орчим байна. Зарим тохиолдолд илүү хугацаа орж болно.
- Визийн мэдүүлгийг өгөхдөө нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй. Визтэй паспортаа авсны дараагаар тийзээ захиална уу.
- ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг удаашруулах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх 4 долоо хоногийн хугацаа дуусаагүй байхад утсаар эсвэл И-Мэйлээр лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх тул виз мэдүүлэгч бүрт тухайлан хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн туслалцаа, үйлчилгээг ашиглах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.
- Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө. 18 нас хүрээгүй виз мэдүүлэгчийн хувьд асран хамгаалах эрх бүхий хүмүүс хамт байлцана. Эцэг эхийн аль нэг нь Германд амьдардаг бол нотариатаар баталгаажуулсан зөвшөөрлийг хавсаргана.

Ерөнхий мэдээлэл

Дараах тохиолдолд дахин нэвтрэх виз мэдүүлэх шаардлагагүй:

- Та Герман улсад оршин суух зөвшөөрөлтэй бөгөөд Монголд түр хугацаагаар (6 сар дотор) ирсэн байгаа бол.

- Паспорт хүчингүй болсноор Герман улсад оршин суух зөвшөөрөлтэй хуудас гэмтээгүй бол хуучин болон шинэ паспорттайгаа (овог нэр өөрчилсөн бол гэрлэлтийн баталгаа / гэрлэлт цуцалсан гэрчилгээг авч явна) шууд нислэгээр Герман улс руу нэвтрэх боломжтой. Та цахим оршин суух зөвшөөрөлтэй (elektronischer Aufenthaltstitel) бол мөн энэ журмын дагуу зорчиж болно.

Та оршин суух зөвшөөрөлтэй паспортаа гээгдүүлсэн, хулгайд алдсан бол Герман улсад дахин нэвтрэх виз мэдүүлэх шаардлагатай.

Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтын жагсаалт

Энэхүү жагсаалтыг ЭСЯ тухайн цаг үеийн мэдлэг, дүгнэлт дээр үндэслэн гаргасан болно. Жагсаалтын бүрэн гүйцэд, үнэн зөв байдал ялангуяа цаг хугацааны хувьд гарч болох өөрчлөлтүүдийн өмнөөс ЭСЯ хариуцлага хүлээхгүй.



Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтуудыг эх хувиас гадна 2 хувь хуулбарын хамт өгнө. Визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа бичиг баримтын эх хувийг буцаан олгоно.

Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө.

Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.

1	Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт ("VIDEX" маягт)	<input type="checkbox"/>
2	Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ.	
3	Хүчинтэй гадаад паспорт	
4	Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрний хуулбар	
5	Үрэгдүүлсэн оршин суух зөвшөөрлийн хуулбар байгаа бол түүнийгээ, хуулбар байхгүй бол оршин суух зөвшөөрөлтэй байснаа нотлох бусад баримт	
Хураамж		
6	Визийн хураамж 75 еврог монгол төгрөгөөр	

Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал

Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх:

Гийм

Гүгүй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу

Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл

Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт дутуу байх нь визийг татгалзах эрсдэлтэй гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно.

_____ газар, огноо, гарын үсэг